



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2014 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргаас 2014 оны 01/1052 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.


2. Энэхүү журмыг 2014 оны 08 сарын 01-ний өдрөөс нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д. БАТТУЛГА

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны
04 дугаар сарын 24-ний өдрийн
56 дугаар тогтоодын хавсралт



НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажиллуулах, Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг (Монгол улсын иргэн ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй), Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалтын "е" (нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн ариун цэвэр, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга технологи, шаардлагыг хэрхэн сахиж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулах) , Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дах хэсэг (Хот, тосгоны оршин суугчдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход тус дэмжлэг үзүүлнэ), 5 дахь хэсэг (Хот, тосгоны нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж, хүнсний болон өргөн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулна.), Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэг (хог хаягдлын талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулан, хангах)-т тус тус заасан арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэх, худалдан авагчдын эрүүл, аюулгүй нөхцөлд үйлчлүүлэх нөхцлийг хангахад чиглэгдсэн харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа нь **Галын аюулгүй байдлын тухай** хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1. (галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг чандлан сахих); 16.1.3. (галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, хэм хэмжээ, стандартыг хангаж ажиллах); 16.1.7. (шинээр баригдаж байгаа барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэргийг байрлуулан ашиглахдаа гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагаар мэргэжлийн дүгнэлтийг гаргуулах); **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай** хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1. (хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах); 18.2.4.(эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох); **Хүнсний тухай** хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 (хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах); 12.1.(Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж,

хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна); **Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай** хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 (Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараах мэдээллийг маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр харьяалах нутаг дэвсгэр дэх хяналтын байгууллагад мэдээлнэ: 6.1.1. хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, байршил, хаяг, утас, факсын дугаар, цахим хаяг; 6.1.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, иргэний регистрийн дугаар, хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журам); 10.1.8 (халдварт өвчнөөр өвчилсөн, эсхүл ийм өвчтөнг асарсан тохиолдол бүрд эрүүл мэндийн үзлэгт хамрагдах); 10.1.9 (хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах); 10.3.1. (хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглоно); **Ариун цэврийн тухай** хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3. (мэргэжлийн хяналтын байгууллага, байцаагчаас ариун цэврийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар тавьсан шаардлагыг хугацаанд нь биелүүлж мэдэгдэх, зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авах); 17.1.4. (гадаад орчноо бохирдуулахгүй байх); **Хог хаягдлын тухай** хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3. (үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх); 9.2.4. (хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллах); 9.2.6. (хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах); 9.2.8. (хог хаягдлыг зориулалтын саванд хийж, зориулалтын хогийн цэгт хаях); 9.2.9. (ил задгай хог хаягдал шатаахгүй байх) дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан **“Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”** болон энэхүү журмын хүрээнд явагдана.

1.3. Түргэн үйлчилгээний цэг эрхлэгчид нь тухайн дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн даргатай гэрээ байгуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна. Гэрээг жил бүр дүгнэж, зөвлөлийн хурлаар хэлэлцэн хугацааг 1 жилээр сунгаж болно.

1.4. Түргэн үйлчилгээний цэг нь 07.00-23.00 цаг хүртэл ажиллана.

Хоёр. Түргэн үйлчилгээний цэгт тавигдах шаардлага

2.1. Түргэн үйлчилгээний цэгийн байгууламжид дараах шаардлага тавигдана. Үүнд:

2.1.1. Түргэн үйлчилгээний цэгийн байгууламж нь тухайн дүүргээс зөвшөөрөгдсөн түр байршилд байрлана.

2.1.2. Тухайн зөвшөөрөгдсөн цэгт түр байрлах түргэн үйлчилгээний цэгийн байгууламжийн тоог дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн Улаанбаатар хотын Ерөнхий менежер гаргаж, тушаалаар батална.

2.1.3. Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний газраас гаргаж, баталсан дизайн, загвартай байна.

2.1.4. Гадна, дотор орчны хяналтын камер, гал унтраах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис зэргийг байрлуулах ба галын аюулгүй байдлын дүгнэлттэй байна.

2.1.5. Зөөврийн бие засах суултуур бүхий ариун цэврийн өрөөтэй байх ба түүнд ашиглах цэвэр ус, үнэр дарагч болон халдваргүйтгэх бодисын нөөцтэй, бохир нөөцлөх сав 10-аас доошгүй байна.

2.1.6. Байгууламжийн гадна талбайд зориулалтын хогийн сав байршуулсан байна.

2.1.7. Байгууламж бүр эргэн тойрны 5 м хүртэлх талбайд тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийнэ.

2.1.8. Худалдаа үйлчилгээ эрхлэх талбайн хэмжээ 10 кв.м-ээс доошгүй байна.

2.2. Түргэн үйлчилгээний цэгийн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаанд дараах шаардлага тавигдана. Үүнд:

2.2.1. Түргэн үйлчилгээний цэгийн худалдаа эрхлэгчид хот тохижилт, цэвэрлэгээний талаар нийслэлээс батлан гаргасан холбогдох журмыг мөрдөн ажиллах ба дүүргийн Нийтлэг үйлчилгээний төвтэй хог хаягдлын гэрээ байгуулан ажиллана.

2.2.2. Зөөврийн бие засах суултуурын бохирыг зайлуулах талаар харъяа нутаг дэвсгэрийн Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын салбар болон Ус сувгийн удирдах газрын аль нэгэнтэй зөвшилцөж гэрээ байгуулсан байна. Цугларсан бохирыг хоногт 1 удаа гэрээнд заасан цэг /худаг/-т зайлуулна.

Гурав. Түргэн үйлчилгээний цэгээр худалдах бараа бүтээгдэхүүн, үзүүлэх ажил үйлчилгээ

3.1. Түргэн үйлчилгээний цэгээр дараах шаардлага хангасан бараа бүтээгдэхүүний худалдаа, ажил үйлчилгээ эрхэлнэ. Үүнд:

3.1.1. Хуулиар хориглоогүй бараа бүтээгдэхүүний худалдаа, ажил үйлчилгээ;

3.1.2. Стандартын шаардлага хангасан хаяг шошготой, үйлдвэрийн сав баглаа боодол бүхий хүнсний бүтээгдэхүүний худалдаа;

3.2. Хүнсний худалдаа эрхлэх бол зориулалтын хөргүүртэй байна.

Дөрөв. Түргэн үйлчилгээний цэгт хориглох зүйл

4.1. Түргэн үйлчилгээний цэгт дараахь бараа бүтээгдэхүүнийг худалдах, ажил үйлчилгээг явуулахыг хориглоно. Үүнд:

4.1.1. Хуулиар хориглосон бараа бүтээгдэхүүн худалдах;

4.1.2. Үйлчилгээний стандартгүй ажил үйлчилгээ эрхлэх;

4.1.3. Хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүн худалдах;

4.2. Дүүргийн “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн даргатай гэрээ байгуулахгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулах;

4.3. Дүүргээс зөвшөөрөгдөөгүй байршилд үйл ажиллагаа явуулах;

4.4. Түргэн үйлчилгээний цэгийг бусдад давхар түрээслэх;

4.5. Гэрээний хугацаа дууссан тохиолдолд үйл ажиллагаа явуулах.

Тав. Хяналт тавих

5.1. Энэхүү журмын 2 дугаар зүйлийн 2.1. дэх хэсгийн хэрэгжилтэнд Нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар болон дүүргийн “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл” хяналт тавина.

5.2. Журмын 3, 4 дүгээр зүйлийн хэрэгжилтэнд Нийслэл, дүүргийн мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, дүүргийн “Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл” хяналт тавина.

Зургаа. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үүрэг, хүлээлгэх хариуцлага

6.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

6.1.1. Энгэрийн тэмдэг бүхий зориулалтын дүрэмт хувцастай байна.

6.1.2. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан шаардлагыг хангаж ажиллана.

6.1.3. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь ажлын байрны болон хувийн ариун цэврийг сахиж, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хагас жил тутам хамрагдаж, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглүүлсэн байна.

6.1.4. Инженерийн шугам сүлжээ засварлах, тавих, өргөтгөх, зам талбай засах зэрэг шаардлагатай засвар, тохижилтын ажил хийх үед газрыг чөлөөлөх үүрэгтэй.

6.2. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь холбогдох гэрээ болон энэхүү журмыг удаа дараа зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоож гэрээг цуцална.

6.3. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн гаргасан зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч, цагдаагийн ажилтан зөрчлийн шинж байдлыг харгалзан холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.